2107	Томилолт, зочны зардал	796.25	-
210702	Дотоод албан томилолт	796.25	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,956.14	56,785.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,238.64	56,785.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,717.50	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,024.93	32,265.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,800.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	58,800.00	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	224.93	32,265.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,500.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	224.93	30,765.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	203,816.86	89,080.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	203,816.86	89,080.85
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	65,253.05	30,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	49,795.85
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,599.31	9,285.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	124,964.50	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд “хүний нөөц, газар, байгалийн баялаг, дэд бүтцийн давуу талдаа тулгуурласан, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, үйлдвэр, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээний харилцан бие биеэ нөхөх зөв зохистой бүтэц бүхий цогц салбаруудыг хөгжүүлж, хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн сум болно” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилтын хүрээнд доорх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- I. Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даацад нийцсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлнэ.
- II. Хадлан бэлчээрийн нөөцийг сайжруулж, бэлчээр ашиглалтын хамтын менежментийг төлөвшүүлнэ.
- III. Сумын хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.
- IV. Жижиг дунд үйлдвэрийг сумын эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- V. Аялал жуулчлалыг сумын эдийн засгийн нэг үндсэн салбар болгон хөгжүүлнэ.
- VI. Сумын нутаг дэвсгэр дэх ашигт малтмалын нөөцийг ашиглах урьдчилсан нөхцөлийг хангана.
- VII. Сумын дэд бүтцийг хөгжүүлж, үйлчилгээний нөхцөлийг сайжруулна.
- VIII. Малчдыг зах зээлтэй холбох оновчтой сүлжээ бүрдүүлнэ.
- IX. Сумын хүн амын тав тухтай сурах, амьдрах, ажиллах орчныг бүрдүүлнэ.
- X. Хувийн хэвшлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд бизнесийн таатай орчин бүрдүүлнэ.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Цэнгэл сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас Цэнгэл сумын төсөвт байгууллагуудын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрддөг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,679.5 сая төгрөгөөр буюу 60.4 хувиар буурсан байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	201.6	149.4	(52.2)
Авлага	443.9	296.2	(147.7)
Бараа материал	249.2	4.5	(244.7)
Үндсэн хөрөнгө	11,769.8	4,494.9	(7,274.9)
Нийт хөрөнгө	55,419.4	87,699.8	32,280.5
Өр төлбөр	89.1	-	(89.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	12,618.2	5,027.8	(7,590.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	12,707.3	5,027.8	(7,679.5)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Дээрх их хэмжээний өөрчлөлт нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 149.4 сая төгрөг болж, өмнөх оноос 52.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	201.6	149.4	(52.2)
Төгрөг	201.6	149.4	(52.2)
Төрийн сангийн харилцах	201.4	149.4	(52.0)
Арилжааны банк дахь харилцах	0.2	0.02	(0.2)
Дүн	201.6	149.4	(52.2)

Эх сурвалж: Аудитын судалгаа.

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдэлтэй буурсан нь эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 296.2 сая төгрөг болж, өмнөх оноос 147.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	6.7	-	(6.7)
Төлбөртэй үйлчилгээний авлага	58.9	-	(58.9)
Зээлийн хүүгийн авлага	-	20.7	20.7
Байгууллагаас авах авлага	15.0		(15.0)
Хувь хүмүүсээс авах авлага	363.3	275.5	(87.8)
Дүн	443.9	296.2	(147.7)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 147.7 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлага 6.7 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 58.9 сая, бусад авлага 15.0 сая, сумын Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 67.1 сая төгрөгөөр тус тус буурсан дүнтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 4.5 сая төгрөг болж, өмнөх оноос 244.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	18.7	-	(18.7)
Тусгай зориулалттай материал			-
Эм боох материал	18.7	-	(18.7)
Дуусаагүй үйлдвэрлэл			-
Хангамжийн материал	230.5		(230.5)
Бичиг хэргийн материал	1.1	-	(1.1)
Аж ахуйн материал	132.3	0.2	(132.1)
Түлш, шатах тослох материал	0.9	-	(0.9)
Барилгын засварын материал	0.3	-	(0.3)
Хүнсний материал	74.4	-	(74.4)
Бусад хангамжийн материал	21.6	4.3	(17.3)
Мал амьтад	-	-	-
Дүн	249.2	4.5	(244.7)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Бараа материалын данс 244.7 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материалтай холбоотой байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын илрүүлэлт:

- *Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.*

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Нөөцийн барааны үлдэгдэл 82.8 сая төгрөгийн болж, 40.0 сая төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн тэжээлийн дүнгээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн буюу Нөөцийн бараа үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	42.8	82.8	40.0
Тэжээлийн нөөц	42.8	82.8	40.0
Дүн	42.8	82.8	40.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,494.8 сая төгрөг болж, өмнөх оноос 7,274.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	11,555.2	4,333.3	(7,221.8)
Барилга, байгууламж, орон сууц	8,349.0	1,436.8	(6,912.2)
Авто-тээврийн хэрэгсэл	81.5	15.4	(66.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,058.7	1,638.3	(420.4)
Тавилга, аж ахуйн эд хогшил	137.4	17.3	(120.1)
Зам, гүүрийн байгууламж	813.2	1,044.5	231.4
Бусад үндсэн хөрөнгө	52.9	180.9	128.0
Ном	62.4	-	(62.4)
Биет бус хөрөнгө	214.7	161.6	(53.1)
Программ хангамж	0.5	-	(0.5)
Бусад биет бус хөрөнгө	214.2	161.6	(52.6)
Дүн	11,769.8	4,494.9	(7,274.9)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Үндсэн хөрөнгийн данс 7,274.9 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- *Үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.*

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс оны эцэст үлдэгдэлгүй, өмнөх оны 89.1 сая төгрөгийн өглөг бүрэн барагдсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	56.5	-	(56.5)
Ажилчидтай холбогдсон өглөг	51.8	-	(51.8)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	4.7	-	(4.7)
Бусад өглөг	32.6	-	(32.6)
Байгууллагад төлөх өглөг	30.5	-	(30.5)
Хувь хүмүүст төлөх өглөг	2.1	-	(2.1)
Дүн	89.1	-	(89.1)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аудитын илрүүлэлт:

- Өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 520.7 сая төгрөг болж, өмнөх оноос 2,344.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,865.5	520.7	(2,344.7)
Хуримтлагдсан үр дүн	5,565.5	4,033.8	(1,531.7)
Өмнөх үеийн үр дүн	5,723.8	11,720.4	5,996.6
Тайлант үеийн үр дүн	(158.3)	(7,686.6)	(7,528.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,187.2	473.3	(3,714.0)
Дүн	12,618.2	5,027.8	(7,590.4)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлттэй холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 2414.8 сая, хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд 3714.0 сая төгрөгийн бууруулах бичилт, өмнөх үеийн үр дүн дансанд 6,154.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх бичилт хийгдсэнтэй холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 7,590.4 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Цэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,379.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,027.8 сая төгрөгийг урсгал зардалд, 351.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийт зардлын 1,673.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 505.7 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 200.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Цэнгэл сум нь 2022 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,904.9 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс орон нутгийн төсвөөс 1,392.6 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 427.7 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 84.6 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Батлагдсан төсөв нийт дүнгээрээ 474.2 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан ба үүнээс орон нутгийн төсвөөс 24.6 сая төгрөгийн төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого /хоршоо хөгжүүлэх сан/-гийн 115.4 сая төгрөгөөр тасарсан, орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой дутуу авсан санхүүжилтээр тус тус хэмнэлттэй харагдаж байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,899.8 сая төгрөг буюу 79.9 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн тасарсан орлого, дутуу авсан санхүүжилттэй холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 84.6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 51 дугаар тогтоолоор Цэнгэл сумын 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 554.7 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2022 оны 95 дугаар тодотголоор 561.7 сая төгрөгөөр буюу 7.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 14 дугаар хуралдааны тогтоолоор 2022 орлогын төлөвлөгөөг 141.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 702.9 сая төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 695.8 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 7.1 сая төгрөгөөр буюу 1 хувиар тасарсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	697.0	647.8	-49.2	93.1
II.Татварын бус орлого	5.9	48.0	42.1	6.9
Нийт дүн	702.9	695.8	-7.1	100.0

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос цалин хөлсний орлого 1.8 сая, үйл ажиллагааны орлогын албан татвар 47.4 сая, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 4.1 сая, үл хөдлөх хөрөнгийн татвар 2.7 сая, агнуурын нөөцийн төлбөр 50.1 сая, хог хаягдлын хураамж 1.0 сая, газрын төлбөр 27.4 сая төгрөгөөр тус тус тасарсан нь төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байна.

Хөрөнгө борлуулсны орлогоос 2.0 сая, бууны албан татвар 0.1 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.04 сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамж 0.4 сая, ойн нөөцийн төлбөр 24.4 сая, хүү торгуулийн орлого 11.8 сая төгрөгөөр давж, төлөвлөгдөөгүй бусад нэр заагдаагүй орлогоос 30.3 сая төгрөгийн, малд ногдох албан татвараас 58.1 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сумын орон нутгийн орлогын тасарсан шалтгаан нь зарим орлогын төлөвлөгөө үндэслэлгүй өндөр төлөвлөгдсөнтэй холбоотой байна.,

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 90.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 695.8 сая төгрөгийн татварын орлого оруулж, орон нутгийн төсвийн байгууллагуудаас 24.6 сая төгрөгийн санхүүжилт төвлөрч, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 34.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар: /мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	111.1	97.1	14.0
2	Сумын ЗДТГ	828.6	587.4	241.2
3	Ерөнхий боловсролын 1-р сургууль	294.0	294.0	(0.0)
4	Ерөнхий боловсролын 2-р сургууль	121.1	111.1	10.0
5	Ерөнхий боловсролын 3-р сургууль	52.0	51.0	1.0
6	Хүүхдийн 1-р цэцэрлэг	49.2	49.1	0.1
7	Хүүхдийн 2-р цэцэрлэг	42.7	41.8	0.9
8	Хүүхдийн 3-р цэцэрлэг	39.4	39.4	0.0
9	Хүүхдийн 4-р цэцэрлэг	31.1	30.9	0.2
10	Соёлын төв	59.5	46.0	13.5
11	Эрүүл мэндийн төв	44.8	44.6	0.2
12	ОНХСан	505.7	505.9	(0.2)
13	СХС	200.0	1.5	198.5
Нийт дүн		2,379.2	1,899.8	479.4

Эх сурвалж: Аудитын судалгаа

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсөвт байгууллагуудад төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжид 30.0 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 49.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 9.3 сая төгрөгийн нийт 89.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 56.8 сая төгрөгийг зарцуулж, 32.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 3 дүгээр сарын 02-ны өдрийн 1/101 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,900.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 79.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд дараах зардлуудыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: цалин хөлсний зардлыг 14.5 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 23.6 сая, хангамж, бараа материалын зардлыг 0.08 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 1.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 0.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 207.4 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 4.7 сая, хөрөнгийн зардлыг 123.5 сая төгрөгөөр нийт 479.3 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад бүрэн байршуулсан байна.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байхаар аудитын албан шаардлага өгөгдсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт байгууллагуудад завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт №4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цэнгэл сумын Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 3 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй, акт тогтоогдоогүй, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт №5: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар										
2	Цэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал										
3	Цэнгэл сумын ОНХСан										
4	Цэнгэл сумын Хоршоо хөгжүүлэх сан										
Нийт дүн		-	-	-	-	-	-	-	-	-	-

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
						Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

